



ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ
АЖИЛЛАГААНЫ ГАЗАР**

Б корпус, Засгийн газрын IX байр,
Энхтайваны өргөн чөлөө 16, Баянзүрх дүүрэг,
Улаанбаатар хот, 13381
Утас/Факс: (976-51) 26 00 62
Цахим шуудан: info@spa.gov.mn
Цахим хуудас: www.spa.gov.mn

2024.06.13 № А-1/2468

танай _____-ны № _____-т

Тодруулга хүргүүлэх тухай

Тус газраас зарласан ЦХХХЯ/20240101003 дугаартай XXV.1.7 “Үүрэн холбооны сүлжээ сайжруулах станц /Хөвсгөл, Төмөрбулаг, Цагаан-Үүр, Эрдэнэбулган, Галт, Түнэл, Жаргалант, Баянзүрх сум/” төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтад оролцохыг сонирхогч этгээдээс тодруулга авах хүсэлт ирүүлсний дагуу захиалагч Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас ирүүлсэн хариуг хавсралтаар хүргүүлж байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 19.2-т “Захиалагч тодруулга авах хүсэлт хүлээн авснаас хойш тодруулгыг тендер хүлээн авах эцсийн хугацаанаас ажлын хоёроос доошгүй өдрийн өмнө бичгээр гаргана” гэж заасны дагуу тендер нээх хугацааг доорх байдлаар өөрчилж байна.

- ТШЗ 26.1 “Огноо: 2024 оны 06 дугаар сарын 17-ны өдөр, Цаг: 10 цаг 00 минут” гэснийг “Огноо: 2024 оны 06 дугаар сарын 19-ний өдөр, Цаг: 10 цаг 00 минут” гэж;

- ТШЗ 26.2 “Огноо: 2024 оны 06 дугаар сарын 17-ны өдөр, Цаг: 10 цаг 05 минут” гэснийг “Огноо: 2024 оны 06 дугаар сарын 19-ний өдөр, Цаг: 10 цаг 05 минут” гэж тус тус өөрчлөв.

ДАРГА



Ц.БАТЗУЛ



ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЯАМ

Сүхбаатарын талбай1, 1 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, 15160
Утас: 51-265102 Факс: 11-330780
Цахим шуудан: info@mddc.gov.mn
Цахим хуудас: www.mddc.gov.mn


2024.06.14 № 03/1248

танай 2024.06.10 -ны № А-1/2419 -т

Тодруулгын хариу өгөх тухай

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй XXV.1.7 “Үүрэн холбооны сүлжээ сайжруулах станц /Хөвсгөл, Төмөрбулаг, Цагаан-Үүр, Эрдэнэбулган, Галт, Түнэл, Жаргалант, Баянзүрх сум” төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтад оролцохыг сонирхож буй этгээдэд дараах тодруулгын хариуг хүргүүлж байна.

Техникийн байрны ханын материал нь тендерийн баримт бичгийн техникийн тодорхойлолтын 3 дахь хэсгийн "Техникийн байранд тавигдах шаардлага"-ын дагуу байна.



Цахим хөгжил харилцаа холбооны яам
Удирдлага
Төрийн нарийн бичгийн дарга
Батаа Батцэцэг
2024-06-14 13:23:25